



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А/919

Мандалговь

Газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйл 38.1, 38.2, 38.4 дэх заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Сайнцагаан сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэр (Нарлаг-6-6066)-д байршилтай иргэн Цэндийн Эрдэнэцэцэг (ЗЮ:72021323)-ийн орон сууцны зориулалттай 225 м.кв (0,02га) газрыг иргэн Энхсайханы Пүрэвжав (ЗК:04212210)-т зориулалтаар нь шилжүүлж 11 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Дээрх иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), мөн гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт, Сайнцагаан сумын Засаг дарга, бөгөөд Мандалговь хотын захирагч (С.Бат-Оргил), аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга (Ш.Төрбат) нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн А/206 дугаар захирамжийн иргэн Ц.Эрдэнэцэцэг-т холбогдох хэсэг мөн газар эзэмших 0000064279 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822100028